

## **ТӨРИЙН АРХИВУУДЫН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН**

2014 оны 03 сарын 25

Улаанбаатар хот

Үндэсний архивын газрын даргын 2003 оны 153 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн архивын үйл ажиллгээний тайлан, статистик мэдээ гаргах, үнэлэх журам”-ын дагуу төрийн архивуудын 2014 оны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийлээ.

Хяналт, шинжилгээ-үнэлгээнд төрийн **33** архив хамрагдсан. Үндэсний төв архив /цаашид “ҮТА” гэх/ нь Архивын ерөнхий газар /цаашид “АЕГ” гэх/-ын хяналт, шинжилгээ-үнэлгээнд орж дүгнэгддэг, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 50-д заасны дагуу Тагнуулын ерөнхий газрын тусгай архивын данс, бүртгэл нууцын зэрэглэлд ордог тул уг архивыг хяналт, шинжилгээ-үнэлгээнд хамруулаагүй болно.

Төрийн архивуудаас 2014 онд хийж гүйцэтгэсэн ажлын бичвэр тайланг, 14 үзүүлэлт, 92 асуулга бүхий статистик мэдээний хамт гаргуулан авч, холбогдох баримтууд, өнгөрсөн жилийн хяналт, шинжилгээ-үнэлгээний дүнтэй харьцуулан үзсэний үндсэн дээр 2014 оны үйл ажиллагаанд нь хяналт, шинжилгээ-үнэлгээ хийлээ. Ингэхдээ аймаг, нийслэлийн архивыг тусад нь, салбар, төрөлжсөн архивыг тусад нь харьцуулан үзлээ. Аймаг, нийслэлийн архивуудын 2014 оны үйл ажиллагааны нэгдсэн тоон үзүүлэлтийг 1 дүгээр, салбар архивуудын 2014 оны үйл ажиллагааны нэгдсэн тоон үзүүлэлтийг 2 дугаар, төрөлжсөн архивуудын 2014 оны үйл ажиллагааны нэгдсэн тоон үзүүлэлтийг 3 дугаар хавсралтаар харуулав.

Төрийн архивуудын 2014 оны үндсэн үйл ажиллагааг 7 чиглэлд хуваан үзэж, хяналт-шинжилгээ хийлээ. Үүнд:

### **НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР.**

Төрийн архивууд нь 2014 онд, үйл ажиллагаандаа мэдээллийн технологийг нэвтрүүлэх, архивын баримтыг цахим хэлбэрт оруулах ажлыг эрчимжүүлэх, цахим мэдээллийн сан үүсгэх, иргэдэд хөнгөн шуурхай үйлчлэх зорилтыг нийтлэг тавьж, энэ зорилтын хүрээнд ажлын төлөвлөлтийг боловсронгуй болгох, үр дүнг дээшлүүлэх, ажилтнуудаа сургаж бэлтгэх, мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, баримтын аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах зорилго тавьж ажиллажээ. Мөн нийт архивууд АЕГ-аас зохион байгуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллахад анхаарч ажилласан байна.

Нийт төрийн архивууд Архивын тухай хууль, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний

төлөвлөгөө болон “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр” /цаашид “үндэсний хөтөлбөр” гэх/-тэй уялдуулан 2014 оны ажлаа төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Төрийн архивууд 2014 онд нийт **824** ажил төлөвлөснөөс, **776** ажлыг бүрэн гүйцэтгэсэн ба төлөвлөгөөний биелэлт **94.2%** байна.

Төрийн архивуудаас удирдлага зохион байгуулалтын талаар авсан зарим арга хэмжээг авч үзвэл:

1. Говь-Алтай, Төв аймгийн Архивын тасгууд архивын шинэ байртай болж, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар /цаашид “ГХГЗЗГ” гэх/-ын Мэдээллийн төв, Цагдаагийн ерөнхий газар /цаашид “ЦЕГ” гэх/-ын Төв архивын газар, Нийслэлийн архивын газар, Говь-сүмбэр аймгийн Архивын тасаг архивын байрандаа засвар хийсэн байна. Мөн Нийслэлийн архивын газрын хадгаламжийн сангийн өрөө байрны багтаамж багассан тул 903 хадгаламжийн нэгж /цаашид “ХН” гэх/-ийг “Орбит комплекс” ХХК-тай гэрээ байгуулж, түрээсийн байранд хадгалж байна.
2. Архивын үйл ажиллагаанд зориулж шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, архивын баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд **10** төрийн архив **256** ширхэг нягтруулсан шүүгээ, тавиур худалдан авсан байна. Тухайлбал: Нийслэлийн архивын газар 15 ширхэг төмөр тавиур, Завхан аймгийн Архивын тасаг 20 секц нягтруулсан шүүгээ, Орхон аймгийн Архивын тасаг 10 ширхэг тавиур, ГХГЗЗГ-ын Мэдээллийн төв 13 секц нягтруулсан шүүгээ, 4 тавиур, ЦЕГ-ын Төв архивын газар 36 секц нягтруулсан шүүгээ тус тус худалдан авчээ.
3. Нийт архивууд "Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтанд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам"-ыг хэрэгжүүлэх ажлыг салбар, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсны дүнд 2014 онд **91** ажилтан мэргэшлийн “Ахлах” зэрэг, **33** ажилтан “Тэргүүлэх” зэрэг авсан байна.
4. Төрийн архивуудаас 2014 онд зохион байгуулсан сургалт, сургалтанд хамрагдсан хүний тоог 2013 оныхтой харьцуулан үзвэл сургалт **33.3%**, хамрагдсан хүний тоо **11.3%**-иар тус тус өссөн байна.

График 1



Төрийн архивууд хөмрөг үүсгэгч байгууллагуудынхаа архив, бичиг хэргийн ажилтнуудаа сургах, дадлагажуулахад анхаарч ажиллахын зэрэгцээ төрийн албан

хаагчдын архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор байгууллагуудад сэдэвчилсэн сургалтыг тогтмол зохион байгуулж, үр дүнгийн гэрээнд нь бие даасан үзүүлэлт оруулж дүгнэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн нь сайшаалтай байна.


## ХОЁР. АРХИВЫН САН ХӨМРӨГИЙН НӨХӨН БҮРДҮҮЛЭЛТИЙН ТАЛААР.

Нөхөн бүрдүүлэлтийн ажил төрийн архивуудад хэвийн явагдаж байна.

### 2.1. Аймаг, нийслэлийн архивын нөхөн бүрдүүлэлт.

Аймаг, нийслэлийн архивуудад хадгалагдаж байгаа нийт баримтын тоо хэмжээний өсөлт, бууралтыг 2012-2014 оны байдлаар харьцуулан гаргавал:

График 2



Аймаг, нийслэлийн архивын сан хөмрөгт, нийтдээ, 2012 онд 717030 ХН хадгалагдаж байсан бол 2013 онд 40301 ХН-ээр нэмэгдэж 757331 ХН, 2014 онд **849867** ХН болж, **92536** ХН-ээр нэмэгдсэн байна.

Аймаг, нийслэлийн архивуудын нийт хөмрөгийн тоо 2012 онд 3882, 2013 онд 4118 байсан бол, 2014 онд 113 хөмрөг нэмэгдэж, 4231 болж өөрчлөгджээ. Жишээ нь: Дорноговь аймгийн Архивын тасгийн хөмрөгийн тоо 2013 онд 184, 2014 онд 195, Говь-Алтай аймгийн Архивын тасгийн хөмрөгийн тоо 2013 онд 209, 2014 онд 219, Сэлэнгэ аймгийн Архивын тасгийн хөмрөгийн тоо 2013 онд 108, 2014 онд 118 болж өссөн бол Ховд, Төв аймгуудын Архивын тасгийн хөмрөгийн тоо 2014 онд өөрчлөгдөөгүй байна.

2014 онд нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан баримтын тоон үзүүлэлтийг аймаг, нийслэлийн архив тус бүрээр нь авч үзвэл:

№	Архивын нэр	Нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан ХН-ийн тоо	№	Архивын нэр	Нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан ХН-ийн тоо
1	Нийслэлийн	<b>29,389</b>	12	Орхон аймаг	3,675

	архивын газар				
2	Баянхонгор аймаг	<b>15,716</b>	13	Дорноговь аймаг	1,665
3	Завхан аймаг	<b>8,922</b>	14	Дорнод аймаг	1,379
4	Говь-Алтай аймаг	<b>7,830</b>	15	Сэлэнгэ аймаг	1,114
5	Говьсүмбэр аймаг	<b>6,500</b>	16	Сүхбаатар аймаг	642
6	Өвөрхангай аймаг	6,277	17	Дархан-Уул аймаг	633
7	Архангай аймаг	5,666	18	Баян-Өлгий аймаг	554
8	Хөвсгөл аймаг	5,481	19	Увс аймаг	503
9	Төв аймаг	5,168	20	Булган аймаг	255
10	Дундговь аймаг	5,066	21	Хэнтий аймаг	212
11	Өмнөговь	4,659	22	Ховд	205
<b>НИЙТ ДҮН ТОО</b>					<b>111511 ХН</b>

Үүнээс үзэхэд: 2014 онд аймаг, нийслэлийн архивууд нийт 111511 ХН хүлээн авсан байгаа бөгөөд тэдгээрийн 81% нь удирдлагын баримт, 10% нь тусгай төрлийн баримт, 2.8% нь зураг төслийн баримт, 2.3% нь гэрэл зургийн баримт эзэлж байна. Хөмрөг үүсгэгч байгууллагын төрлийг нь авч үзвэл: төрийн байгууллага 58% /473/, төрийн бус байгууллага 35% /283/, хувь хүн 7% /49/-ийг тус тус эзэлж байна.


Архивын сан хөмрөгт шинээр хүлээн авсан баримтын тоогоороо Нийслэлийн архивын газар, Баянхонгор, Завхан, Говь-Алтай, Говь-сүмбэр аймгийн Архивын тасгууд тэргүүлж байгаа бөгөөд Ховд, Хэнтий, Булган аймгийн Архивын тасгууд сүүлийн байруудад орж байна.

2014 онд аймаг, нийслэлийн архивуудын хөмрөг, баримтын тоо нэмэгдэж, нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан баримтын тоо 2013 оныхтой харьцуулбал 55,3%-иар өссөн байгаа хэдий ч тоон мэдээнүүд буруу байна. Тухайлбал, аймаг, нийслэлийн архивуудад хадгалагдаж байсан нийт баримтын тоо 2014 онд 92532 ХН-ээр нэмэгдсэн атал, аймаг, нийслэлийн архив тус бүрийн 2014 онд нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан ХН-ийн дүн тоог нэмж үзэхэд 111511 ХН болж **18975** ХН-ээр зөрж байна.

## **2.2. Салбар архивуудын нөхөн бүрдүүлэлт**

Салбар архивуудад хадгалагдаж байгаа нийт баримтын тоо хэмжээний өсөлт, бууралтыг 2012-2014 оны байдлаар харьцуулан гаргавал:

График 3



Салбар архивуудын сан хөмрөгт, нийтдээ, 2012 онд 18394687 ХН хадгалагдаж байсан бол 2013 онд 3149390 ХН-ээр нэмэгдэж 21544077 ХН, 2014 онд **17487127** ХН болж, **4056950** ХН-ээр хасагдсан байна.

Улсын бүртгэлийн төв архив нь 37,732,991 ХААТР маягтыг устгалд оруулсан, Цаг уур, орчны шинжилгээний газар /цаашид ЦУОШГ” гэх/-ын Архив, мэдээллийн хэлтэс 94 ХН-ийг байгууллагын архивт шилжүүлсэн нь ийнхүү баримтын тоо хэмжээ буурахад нөлөөлжээ.


Салбар архивуудын нийт хөмрөгийн тоо 2012 онд 355, 2013 онд 333, 2014 онд 12 хөмрөг нэмэгдэж 345 хөмрөгтэй болсон ба 2014 онд нийт **926** ХН, **3326** зураг /салбарын/, **87577** хувийн хэрэг, **175937** иргэний бүртгэлийн маягтыг тус тус хүлээн авч сан хөмрөгөө баяжуулсан байна.

Нэр	Баримтыг нь шилжүүлэн авсан байгууллагын тоо	Баримтын тоо
Геологийн мэдээллийн төв архив	Зохион байгуулалтын нэгж	320 ХН, 3326 мэргэжлийн зураг
Улсын бүртгэлийн төв архив	21 аймаг, Нийслэлийн бүртгэлийн газар, хэлтсүүд	ЭХХЭБАХ: 87577 хувийн хэрэг ИБАХ: 175937 иргэний бүртгэлийн маягт, 303 ХН
ЦУОШГ-ын Архив, мэдээллийн хэлтэс	25	178 ХН
ГХГЗЗГ-ын Мэдээллийн төв	145	125 ХН
<b>НИЙТ ДҮН ТОО</b>		<b>926 ХН, 3326 зураг, 87577 хувийн хэрэг 175937 иргэний бүртгэл</b>

### **2.3. Төрөлжсөн архивуудын нөхөн бүрдүүлэлт**

Төрөлжсөн архивуудад хадгалагдаж байгаа нийт баримтын тоо хэмжээний өсөлт, бууралтыг 2012-2014 оны байдлаар харьцуулан гаргавал:

График 4



Төрөлжсөн архивын сан хөмрөгт, нийтдээ, 2012 онд 68595 ХН хадгалагдаж байсан бол 2013 онд 4951 ХН-ээр нэмэгдэж 73546 ХН, 2014 онд 4586 ХН-ээр нэмэгдэж, **78132** ХН-тэй болсон ба хөмрөгийн тоо 2012 онд 609, 2013 онд 686, 2014 онд 27 хөмрөг нэмэгдэж **713** болсон дүн гарч байна.

2014 онд нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан баримтын тоон үзүүлэлтийг төрөлжсөн архив тус бүрээр нь авч үзвэл:

№	Төрөлжсөн архивын нэр	Хөмрөг үүсгэгч байгууллагын тоо	Хүлээн авсан ХН-ийн тоо
1	Эрүүгийн хэргийн төв архив	36	<b>4600</b>
2	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны Төрөлжсөн архив	36	<b>2092</b>
3	ХХЕГ-ын төв архив	4	<b>1920</b>
4	Батлан хамгаалахын төв архив	14	<b>1399</b>
5	ЦЕГ-ын Төв архивын газар	9	<b>1262</b>
6	Гадаад харилцааны төв архив	39	<b>1238</b>
7	Төмөр замын төрөлжсөн архив	10	<b>483</b>
	Дүн	<b>148</b>	<b>12 994 ХН</b>

Дээрх хүснэгтээс харахад төрөлжсөн архивууд 2014 онд нийт **12994** ХН-ээр сан хөмрөгөө нөхөн бүрдүүлсэн ба архивт хүлээн авсан баримтын тоогоороо Эрүүгийн хэргийн төв архив, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Төрөлжсөн архив, ХХЕГ-ын Төв архив тэргүүлж байна.

Гэвч төрөлжсөн архивуудад хадгалагдаж буй баримтын тоо хэмжээний өсөлт нь архив тус бүрт нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан баримтын тоо хэмжээтэй бас зөрж байгаа нь анхаарал татаж байна. Жишээ нь нийт төрөлжсөн архивуудад хадгалагдаж буй баримтын тоо 2014 онд 4586 ХН-ээр нэмэгдсэн байхад хүлээн авсан баримтын тоо 12994 ХН-ээр нэмэгдсэн болж, **8408** ХН-ээр зөрж байна.

2.4. **Дүгнэлт:** 2014 онд нийт төрийн архивуудын хөмрөг, баримтын тоо нэмэгдэж, нөхөн бүрдүүлэлтийн ажил нь төлөвлөснийхөө дагуу хэвийн явагдсан гэж үзэж болохоор байна.

Гэвч архивт хадгалагдаж буй баримтын тоо хэмжээний өсөлт нь нөхөн бүрдүүлэлтээр авсан ХН-ийн тоотой адил байх ёстой ч зөрүүтэй байгаа нь хяналт-шинжилгээний ажилд хүндрэл учруулж, бодит дүгнэлт гаргах боломжгүй болгож байна.

Ийнхүү тоон мэдээ зөрүүтэй байгаа нь:

- Тайлан мэдээгээ төрийн архивууд үнэн зөв гаргаж чаддаггүй;
- Архивууд сан хөмрөгтөө хүлээн авсан удирдлагын баримтаас бусад тусгай төрлийн баримтууд /гэрэл зургийн баримт, зураг төслийн баримт, хувийн гаралтай баримт г.м/-ын иж бүрдлийг бие даасан ХН болгон бүртгэдэггүй;
- Хувийн хөмрөгт хүлээн авсан өөр өөр төрлийн баримтуудыг нэг ХН болгон бүртгэдэг;
- Тоо бүртгэлийн баримт бичгийг үнэн зөв хөтөлж, тухай бүр тэмдэглэл хийж хэвшээгүй;
- Архивын дарга нар өөрсдөө мэдээ тайлангаа гаргаж нэгтгэдэггүй, гаргасныг нь хянадаггүй зэрэгтэй холбоотой байна.

Мөн АЕГ-аас тусгай төрлийн баримтыг эмхлэн цэгцлэх, сан хөмрөгөө нөхөн бүрдүүлэх, данс бүртгэл үйлдэх, тоон мэдээ, тайлан гаргах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх, заавар, журам, гарын авлага боловсруулж, мөрдүүлэх шаардлагатай болсныг хяналт-шинжилгээний дүн харуулж байна.

## **ГУРАВ. НЯГТЛАН ШАЛГАЛТЫН ТАЛААР.**

### **3.1. Төрийн архивуудын дэргэдэх БНШАЗК-ын үйл ажиллагаа**

Нийт төрийн архивуудын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисс /цаашид “БНШАЗК” гэх/-ын үйл ажиллагаа жигд сайн байна. Үүнд:

#### **3.1.1. Аймаг, нийслэлийн архивуудын дэргэдэх БНШАЗКын үйл ажиллагаа**

Аймаг, нийслэлийн архивуудын дэргэдэх БНШАЗК 2014 онд нийт **92** удаа хуралдаж, **1920** асуудлыг хэлэлцэж баталсан байгаа бөгөөд энэ үзүүлэлт нь 2013 оныхтой харьцуулахад **13,8%**-иар өссөн байна.

Аймаг, нийслэлийн архивуудын дэргэдэх БНШАЗК нь 2014 онд нийт 698 данс, түр хадгалах баримтын бүртгэл 378, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт 364, Устгах бичгийн жагсаалт 227, Хадгалах хугацааны жагсаалт 82, Үнэт баримтын бүртгэл 1-ийг тус тус хэлэлцэж баталсан байна. Уг хурлаар хэлэлцсэн асуудлуудын дийлэнх нь данс бүртгэл байгаа бөгөөд зөвхөн Хөвсгөл аймгийн Архивын тасаг л архивын сан хөмрөгөөс илрүүлсэн үнэт баримтын бүртгэлээ БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлжээ.

БНШАЗК-ын хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлуудыг аймаг, нийслэлийн архив тус бүрээр гаргавал:

№	Архивуудын нэр	БНШАЗК-ийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлууд, тоо					Нийт дүн
		Хөтлөх хэргийн нэр, төрлийн жагсаалт баталсан	Баталсан данс	Устгах бичгийн жагсаалт	Хадгалах хугацааны жагсаалт	Түр хадгалах баримтын бүртгэл	
1.	Нийслэлийн архивын газар	35	128	98	2	76	339
2.	Архангай аймгийн Архивын тасаг	-	10	1	2	2	15
3.	Баян-Өлгий аймгийн Архивын тасаг	10	20	-	5	1	36
4.	Баянхонгор аймгийн Архивын тасаг	165	294	-	-	-	459
5.	Булган аймгийн Архивын тасаг	2	-	-	-	-	2
6.	Говь-Алтай аймгийн Архивын тасаг	-	43	32	-	-	75
7.	Говьсүмбэр аймгийн Архивын тасаг	23	35	4	-	23	85
8.	Дархан-Уул аймгийн Архивын тасаг	2	6	4	-	5	17
9.	Дорноговь аймгийн Архивын тасаг	14	78	16	1	25	134
10.	Дорнод аймгийн Архивын тасаг	-	-	5	-	10	15
11.	Дундговь аймгийн Архивын тасаг	2	-	3	2	4	11
12.	Завхан	4	32	13	-	4	53



	аймгийн Архивын тасаг						
13.	Орхон аймгийн Архивын тасаг	17	29	17	5	42	110
14.	Өвөрхангай аймгийн Архивын тасаг	-	21	-	-	91	112
15.	Өмнөговь аймгийн Архивын тасаг	12	6	15	-	38	71
16.	Төв аймгийн Архивын тасаг	46	7	9	37	35	134
17.	Сүхбаатар аймгийн Архивын тасаг	4	20	-	23	-	47
18.	Сэлэнгэ аймгийн Архивын тасаг	2	20	-	-	15	37
19.	Увс аймгийн Архивын тасаг	1	-	1	1	-	3
20.	Ховд аймгийн Архивын тасаг	-	4	-	3	-	7
21.	Хөвсгөл аймгийн Архивын тасаг	24	32	7	-	7	70
22.	Хэнтий аймгийн Архивын тасаг	1	-	2	1	-	4

Хамгийн олон асуудал хэлэлцсэн архив нь Баянхонгор аймгийн архивын тасаг /459/, Нийслэлийн архивын газар /339/, Дорноговь /134/, Төв /134/ аймгийн Архивын тасгууд байна. Харин Увс аймгийн Архивын тасаг 2014 онд 503 ХН, Хэнтий аймгийн Архивын тасаг 212 ХН, Булган аймгийн Архивын тасаг 255 ХН-ийг тус тус нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан байгаа боловч тухайн баримтын данс, бүртгэлийг БНШАЗК-ын хурлаар хэлэлцэж батлуулаагүй байгаа нь Төрийн архивын ажлын үндсэн зааврын 3.2.2-т заасан "...архивт шилжүүлэх баримтын данс бүртгэлийг 3 хувь үйлдэж, төрийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар

батлуулсан байна” гэснийг зөрчсөн ба БНШАЗК-ын үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна.

### **3.1.2. Салбар, төрөлжсөн архивуудын дэргэдэх БНШАЗК-ын үйл ажиллагаа**

2014 онд салбар архивуудын дэргэдэх БНШАЗК 8 удаа хуралдаж 20 асуудал, төрөлжсөн архивууд 20 удаа 128 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Салбар болон төрөлжсөн архивуудын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар 2014 онд хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын тоог 2013 онтой харьцуулж үзвэл, 2014 онд 46,8%-иар буурсан байна.

Салбар, төрөлжсөн архивуудын дэргэдэх БНШАЗК нь 2014 онд нийт 197 данс, түр хадгалах баримтын бүртгэл 71, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт 11, Устгах бичгийн жагсаалт 105, Хадгалах хугацааны жагсаалт 44-ийг тус тус хэлэлцэж баталсан байна. Хэлэлцсэн асуудлын тоогоороо төрөлжсөн архивуудаас Батлан хамгаалахын төв архив /109/, салбар архивуудаас Геологийн мэдээллийн төв архив /10/ хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа бол Төмөр замын төрөлжсөн архив 10 байгууллагаас баримтыг хүлээн авсан бол боловч 2014 онд 1 л асуудал хэлэлцсэн байгаа нь БНШАЗК-ын хурлын үйл хангалтгүй байгааг харуулж байна.

### **3.2. Төрийн архивуудын иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажил**

Архивын баримтыг цахимжуулах ажлын хүрээнд нийт төрийн архивууд 2014 онд сан хөмрөгийн баримтанд иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажлыг хийж данс, бүртгэлээ шинэчлэхэд анхаарч, Төрийн архивын үндсэн зааврын 3.5.1-д заасныг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **3.2.1. Аймаг, нийслэлийн архивуудын иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажил**

2014 онд аймаг, нийслэлийн архивууд нийт 439 хөмрөгийн 470 дансны 64917 ХН-д иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажил хийжээ. Үүнийг аймаг, нийслэлийн архив тус бүрээр нь авч үзвэл:

№	нэр	Нягтлан шалгалт хийсэн ХН-ийн тоо	№	нэр	Нягтлан шалгалтын хийсэн ХН-ийн тоо
1	Нийслэлийн архивын газар	<b>12687</b>	12	Ховд аймаг	<b>1670</b>
2	Орхон аймаг	<b>9100</b>	13	Завхан аймаг	<b>1648</b>
3	Баянхонгор аймаг	<b>6919</b>	14	Говьсүмбэр аймаг	<b>1520</b>
4	Увс аймаг	<b>5855</b>	15	Төв аймаг	<b>1496</b>
5	Говь-Алтай аймаг	<b>4402</b>	16	Дорноговь аймаг	<b>1159</b>
6	Өмнөговь аймаг	<b>4354</b>	17	Өвөрхангай аймаг	<b>1007</b>
7	Хөвсгөл аймаг	<b>3261</b>	18	Архангай аймаг	<b>866</b>
8	Сэлэнгэ аймаг	<b>3197</b>	19	Хэнтий аймаг	<b>815</b>

9	Дорнод аймаг	2574	20	Баян-Өлгий аймаг	628
10	Дундговь аймаг	2116	21	Булган аймаг	578
11	Дархан-Уул аймаг	1955	22	Сүхбаатар аймаг	210
<b>Нийт дүн</b>				<b>68017 ХН</b>	

Нийслэлийн архивын газар, Орхон, Баянхонгор, Увс аймгийн Архивын тасгууд иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажлын дүнгээр тэргүүлж байгаа бол Баян-Өлгий, Булган, Сүхбаатар аймгийн Архивын тасгууд харьцангуй доогуур үзүүлэлттэй байна.

Аймаг, нийслэлийн архивуудын хөмрөгийн баримтанд хийсэн иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажлын нийт дүн тоо нь архив тус бүрээр гаргасан тоон тайлантай бас зөрж байна.

### **3.2.2. Салбар, төрөлжсөн архивуудын иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажил**

2014 онд, салбар архивууд 367 хөмрөг, 8 данс, 27048 ХН, 447722 хувийн хэрэгт, төрөлжсөн архивууд 53 хөмрөг, 70 данс, 12465 ХН-д тус тус иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийжээ. Үүнийг архив тус бүрээр нь авч үзвэл:

№	Архивын нэр	Нягтлан шалгалт хийсэн ХН-ийн тоо	№	Архивын нэр	Нягтлан шалгалтын хийсэн ХН-ийн тоо
1.	Улсын бүртгэлийн төв архив	12521 ХН, 447722 хувийн хэрэг	7.	Батлан хамгаалахын төв архив	437
2.	ЦУОШГ-ын Архив, мэдээллийн хэлтэс	13037	8.	Гадаад харилцааны төв архив	414
3.	ХХЕГ-ын төв архив	3928	9.	Геологийн мэдээллийн төв архив	650
4.	ЦЕГ-ын Төв архивын газар	1294	10.	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны Төрөлжсөн архив	185
5.	Төмөр замын төрөлжсөн архив	1195	11.	Эрүүгийн хэргийн төв архив	141
6.	ГХГЗЗГ-ын Мэдээллийн төв	840			

**3.3. Дүгнэлт:** Төрийн архивууд цахим архив, сан байгуулах, архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажилтай холбоотой хөмрөгийн баримтанд иж бүрэн нягтлан шалгалт дахин боловсруулалтын ажлыг сүүлийн жилүүдэд эрчимтэй хийж байгаа нь сайшаалтай ч арга зүйн хувьд дутагдалтай явагдаж байна. Зарим

төрийн архивууд саланги тусдаа хөмрөгүүдийн баримтыг нэгтгэж, нэгдсэн хөмрөг үүсгэж байхад, зарим нь нэгдсэн хөмрөгөө салгаж, байгууллага тус бүрээр хөмрөг үүсгэж байна. Зарим төрийн архивуудын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцсэн асуудлын тоо харьцангуй олон байгаа нь үүнтэй холбоотой байна. Мөн төрийн архивуудын дэргэдэх БНШАЗК-ын үйл ажиллагаа жигд биш байгааг хяналт-шинжилгээний дүн харуулж байна.

Цаашид иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийхдээ хөмрөгийг оновчтой, зөв сонгон авах, арга зүйг нь боловсронгуй болгох шаардлага гарч байна.

## **ДӨРӨВ. АРХИВЫН БАРИМТЫН ТОО БҮРТГЭЛ, ТООЛЛОГО**

Төрийн архивууд 2014 онд тоо бүртгэлийн үйл ажиллагаагаа Архивын тухай хуулийн 15.1.7, Төрийн архивын ажлын үндсэн зааврын 4.3.4, 4.3.6, 4.5.1, 4.5.2-т заасны дагуу явуулж байна.

Нийт төрийн архивууд, архивт баримт хүлээн авсан бүртгэл, хөмрөгийн жагсаалт, баримтын данс, хөмрөгийн хуудас зэрэг тоо бүртгэлийн баримт бичгүүдийг шинэчлэн, хадгаламжийн сангийн гэрчилгээ, дансны бүртгэл, хувийн гаралтай баримт хүлээн авсан бүртгэл, кино, дуу, дүрсний баримт хүлээн авсан бүртгэл, акт, зураг төсөл, шинжлэх ухаан, техник технологийн баримт хүлээн авсан акт, гэрэл зургийн бүртгэл, гэрэл зургийн цомгийн бүртгэл, дүрс бичлэгийн баримтын бүртгэл, баримт бичиг устгасан акт зэрэг үндсэн ба туслах тоо бүртгэлийн баримт бичгүүдийг шинээр хөтөлж, хөмрөгийн хэргүүдийг баяжуулсан байна.

### **4.1. Аймаг, нийслэлийн архивуудын тоо бүртгэлийн ажил.**

Аймаг, нийслэлийн архивууд нь 2014 онд тоо бүртгэлийн чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- 138149 ХН-д нэгдсэн тооллого, 50757 ХН-д сэдэвчилсэн тооллого, 28832 ХН-д хэсэгчилсэн тооллого хийсэн;
- 481 данс бүртгэлийг шинэчилсэн;
- 98 хөмрөгийг шинээр үүсгэж, тоо бүртгэл хөтөлсөн байна.

Үүнийг аймаг, нийслэлийн архив тус бүрээр нь авч үзвэл:

№	Нэр	Шинээр үүсгэн, тоо бүртгэл хөтөлсөн хөмрөгийн тоо	Шинэчилсэн данс бүртгэ-лийн тоо	Баримтанд хийсэн тооллого /ХН-ээр/:		
				Сэдэвчилсэн	Хэсэгчилсэн	Нэгдсэн
1	Төв аймгийн Архивын тасаг	1	31	20981	13135	41528
2	Өвөрхангай аймгийн Архивын тасаг	3	3	0	0	44214

3	Дорнод аймгийн Архивын тасаг	6	62	0	0	23371
4	Дундговь аймгийн Архивын тасаг	1	12	10810	2456	8354
5	Дархан-Уул аймгийн Архивын тасаг	6	22	0	0	11693
6	Өмнөговь аймгийн Архивын тасаг	7	26	0	8804	0
7	Сүхбаатар аймгийн Архивын тасаг	3	23	5670	0	0
8	Говьсүмбэр аймгийн Архивын тасаг	2	56	4873	0	0
9	Орхон аймгийн Архивын тасаг	5	29	3900	0	0
10	Хөвсгөл аймгийн Архивын тасаг	3	14	0	0	3261
11	Сэлэнгэ аймгийн Архивын тасаг	10	20	0	3197	0
12	Увс аймгийн Архивын тасаг	5	87	1285	956	0
13	Завхан аймгийн Архивын тасаг	7	18	1648	0	0
14	Булган аймгийн Архивын тасаг	0	0	0	0	578
15	Хэнтий аймгийн Архивын тасаг	4	14	0	231	0
16	Говь-Алтай аймгийн Архивын тасаг	10	33	0	0	0
17	Нийслэлийн архивын газар	0	2	0	0	0
18	Дорноговь аймгийн Архивын тасаг	10	10	0	0	0
19	Баянхонгор аймгийн Архивын тасаг	7	9	0	0	0
20	Баян-Өлгий аймгийн Архивын тасаг	4	0	0	0	0
21	Архангай аймгийн Архивын тасаг	4	10	0	0	0
22	Ховд аймгийн	0	0	0	0	0

	Архивын тасаг					
<b>Дүн</b>		<b>98</b>	<b>481</b>	<b>50757</b>	<b>28832</b>	<b>138149</b>

Төв, Өвөрхангай, Дорнод, Дундговь аймгийн Архивын тасгууд тоо бүтгэлийн ажлын үзүүлэлтээрээ тэргүүлж байгаа ба Ховд аймаг хангалтгүй үзүүлэлттэй харагдаж байна. Говь-Алтай, Нийслэлийн архивын газар, Дорноговь, Баянхонгор, Баян-Өлгий, Архангай Ховд аймгийн архивууд сан хөмрөгийн баримтанд тооллого хийгээгүй байна.

Нийслэлийн архивын газар хамгийн их буюу 12687 ХН-д иж бүрэн нягтлан шалгалт дахин боловсруулалтын ажлыг хийсэн боловч 2 данс бүртгэлийг л шинэчилсэн, Ховд аймгийн Архивын тасаг 1670 ХН-д, Булган аймгийн Архивын тасаг 578 ХН-д, Баян-Өлгий аймгийн Архивын тасаг 628 ХН-д иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийсэн гэж мэдээ ирүүлсэн боловч данс бүртгэлийг шинэчлээгүй, тоо бүртгэлийн 1 ч баримт бичигт өөрчлөлт хөдөлгөөнийг тусгаагүй байгаа нь тоо бүртгэлийн ажил хангалтгүй байгааг харуулж байна.

#### **4.2. Салбар, төрөлжсөн архивуудын тоо бүртгэлийн ажил**

2014 онд нийт салбар, төрөлжсөн архивуудын хэмжээнд шинээр 415 хөмрөгийг үүсгэн, тоо бүртгэлд оруулсан ба 389 данс бүртгэлийг шинэчилж, 5419 ХН-д сэдэвчилсэн тооллого, 31461 ХН-д хэсэгчилсэн тооллого, 76299 ХН, иргэний 12521 ХААТР маягтад нэгдсэн тооллого хийжээ. Үүнийг салбар, төрөлжсөн архив тус бүрээр авч үзвэл:

№	Нэр	Шинээр үүсгэн, тоо бүртгэл хөтөлсөн хөмрөгийн тоо	Шинэчилсэн данс бүртгэлийн тоо	Баримтанд хийсэн тооллого /ХН-ээр/		
				Сэдэвчилсэн	Хэсэгчилсэн	Нэгдсэн
1	Геологийн мэдээллийн төв архив	320	322	0	7931	0
2	Улсын бүртгэлийн төв архив	0	87577 хувийн хэрэг	0	0	Иргэний 12521 ХААТР маягт
3.	ЦУОШГ-ын Архив, мэдээллийн хэлтэс	0	15	0	13037	0
4	ГХГЗЗГ-ын Мэдээллийн төв	0	5	0	0	2753
5	Батлан хамгаалахын төв архив	0	0	0	0	0
6	Төмөр замын	1	1	1491	0	0

	төрөлжсөн архив					
7	ХХЕГ-ын төв архив	0	35	3928	0	0
8	Гадаад харилцааны төв архив	10	11	0	11514	0
9	ЦЕГ-ын Төв архивын газар	80	8224	0	0	0
10	Эрүүгийн хэргийн төв архив	0	17	0	4600	73546
11	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны төрөлжсөн архив	4	3	0	2310	0
<b>Дүн</b>		<b>415</b>	<b>389 ХН 87577 хувийн хэрэг</b>	<b>5419</b>	<b>31461</b>	<b>76299 ХН Иргэний 12521 ХААТР маягт</b>

**4.3. Дүгнэлт:** Төрийн архивууд нь тоо бүртгэлийн баримт бичигт өөрчлөлт хөдөлгөөнийг тэмдэглэж, баримтандаа тооллого хийж, түүний мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Архивын тоо бүртгэлийн баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх ажилд ахиц гарчээ.

Гэвч тоо бүртгэлийн баримт бичигт баримтын өөрчлөлт хөдөлгөөний талаар тухай бүрт нь үнэн зөв, гүйцэд тусгаж хэвшээгүй, гаргасан мэдээ тайлан нь хоорондоо зөрүүтэй, тоо бүртгэлийг буруу гаргасан, баримтыг тоо бүртгэлд оруулах, мэдээ тайлан гаргахдаа Төрийн архивын ажлын үндсэн зааврын 4.2.3-т заасан тоо бүртгэлийн нэгжээр илэрхийлээгүй зэрэг дутагдал байна.

Жишээ нь, ЦЕГ-ын Төв архивын газар 2014 онд 9 байгууллагын 1262 ХН хүлээн авч, 1294 ХН-д иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийсэн мэдээ ирүүлсэн боловч 8224 данс бүртгэлийг шинэчилсэн гэдэг нь эргэлзээтэй байна. Мөн Батлан хамгаалахын төв архив нь 5 хөмрөгийн баримтанд иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийсэн ч 1 ч дансыг шинэчлээгүй нь хяналт-шинжилгээний дүнгээс харагдаж байна.

Цаашид хөмрөгийн баримтанд иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажлыг хийх явцад хуучин данс бүртгэлийг хөмрөгийн хэрэгт хадгалах, дансанд шилжүүлэх хүснэгт үйлдэх, тоо бүртгэлийн баримт бичгүүдэд өөрчлөлт хөдөлгөөнийг бүрэн тэмдэглэх зэрэгт төрийн архивууд онцгой анхаарах шаардлагатай байна.

### ТАВ. ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Нийт төрийн архивууд архивын баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад жигд анхаарч, архивын байртай болох, хадгаламжийн сангийн багтаамжийг нэмэгдүүлэх, архивын өрөө тасалгаанд засвар хийлгэх, нягтруулсан шүүгээ, тавиур шүүгээ, архивын зориулалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангуулах талаар шийдвэр гаргуулж идэвхтэй сайн ажилласан байна.

Төрийн архивуудын хэмжээнд удирдлагын 78083 ХН, зураг төслийн 49459 ХН, 5952 гэрэл зураг, тусгай төрлийн баримтын 2914 ХН, 494281 файлын хими, физик, техникийн шинж чанарт үзлэг хийж, түүний мөрөөр 21431 ХН-д сэлбэн засалт хийжээ.

Архивын баримтын шинж чанарт үзлэг хийсэн, баримт сэлбэн зассан талаарх тоон үзүүлэлтийг архив тус бүрээр нь авч үзвэл:

№	Нэр	Удирдлагын баримт /ХН-ээр/	Зураг төслийн баримт /ХН-ээр/	Гэрэл зураг /ХН-ээр/	Тусгай төрлийн баримт /ХН-ээр, файлаар /	Сэлбэн зассан баримт /ХН-ээр/
<b>Аймаг, нийслэлийн архивууд</b>						
1	Дорнод	22 433	790	0	148	1 965
2	Дархан-Уул	11 693	1	0	0	35
3	Орхон	9 070	84	15	2	900
4	Дундговь	7074	97	11	6	26
5	Сүхбаатар	5 670	0	0	0	105
6	Хөвсгөл	2 124	0	78	0	3 270
7	Сэлэнгэ	3 197	250	136	0	626
8	Говь-Алтай	1 485	0	0	0	1 583
9	Ховд	2 798	0	0	0	0
10	Завхан	2 484	8	0	0	124
11	Төв	679	0	0	0	1 496
12	Баян-Өлгий	275	0	0	0	1 022
13	Баянхонгор	459	0	0	0	120
14	Булган	125	51	165	0	14
15	Өмнөговь	0	0	92	32	122
16	Увс	0	0	0	0	174
17	Говьсүмбэр	51	0	0	0	113
18	Өвөрхангай	0	0	0	0	96
19	Архангай	0	0	0	0	49
20	Нийслэлийн архивын газар	0	0	0	0	30
21	Дорноговь	0	0	0	0	17
22	Хэнтий	0	0	0	0	11
<b>Аймаг, нийслэлийн дүн</b>		<b>69617</b>	<b>1281</b>	<b>497</b>	<b>188</b>	<b>11898</b>
<b>Салбар, төрөлжсөн архивууд</b>						



1	Геологийн мэдээллийн төв архив	2	48178	820	403	236
2	Улсын бүртгэлийн төв архив	0	0	0	0	13
3	ЦУОШГ-ын Архив, мэдээллийн хэлтэс	0	0	0	494281 файл 13 ХН	13
4	Батлан хамгаалахын төв архив	0	0	713	0	1085
5	ГХГЗЗГ-ын Мэдээллийн төв	840	0	0	0	0
6	ХХЕГ-ын төв архив	2486	0	3922		3177
7	Гадаад харилцааны төв архив	2355	0	0	0	1190
8	ЦЕГ-ын Төв архивын газар	1294	0	0	0	107
9	Эрүүгийн хэргийн төв архив	0	0	0	0	141
10	Төмөр замын төрөлжсөн архив	1491	0	0	0	0
11	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны Төрөлжсөн архив	0	0	0	2310	3571
<b>Салбар, төрөлжсөн архивууд</b>		8466	48178	5455	2726 ХН 494281 файл	9533
<b>Нийт төрийн архивуудын дүн</b>		<b>78083</b>	<b>49459</b>	<b>5952</b>	<b>2914 494281 файл</b>	<b>21431</b>

Архивын баримтын шинж чанарт хийх үзлэгийг тооллого болон иж бүрэн нягтлан шалгалтын явцад хийсэн байгаа бөгөөд энэ үзүүлэлтээр Хөвсгөл, Дорнод Говь-Алтай, Дархан-Уул, Орхон аймгийн Архивын тасгууд болон Геологийн мэдээллийн төв архив, ХХЕГ-ын төв архив манлайлсан байна.

### **ЗУРГАА. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГААНЫ САН БҮРДҮҮЛЭЛТ**

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн архивууд эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэх ажилд өмнөх онуудтай харьцуулбал тодорхой хэмжээний ахиц гарсан гэж үзэж болохоор байна. Төрийн

архивуудын хэмжээнд 1627715 эрдэм шинжилгээний лавлах үйлдэж, 1923 дансыг дахин боловсруулсан байна.

**6.1. Аймаг, нийслэлийн архивуудын эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэлт**

Энэ ажлын хүрээнд 2014 онд аймаг, нийслэлийн архивууд нь 1624622 заагч, 202 тойм, 557 танилцуулга, 334 данс шинээр үйлдэж, 585 дансыг шинэчилжээ.

Үйлдсэн заагчуудын тоо их гарсан байгаа нь мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотойгоор программд шивж оруулсан хүний нэр, газар орны нэр, байгууллагын нэр, он цагийн заагчуудыг оруулж тооцсонтой холбоотой байна.

Аймаг, нийслэлийн архивуудаас мэдээллийн сан байгуулах, баримтын дансыг шинэчлэх, хөмрөгүүдийн танилцуулга, тойм бичих, заагч үйлдэх зэрэг эрдэм шинжилгээний лавлахууд үйлдсэн тоон үзүүлэлтээрээ Завхан аймаг, Дархан-Уул аймаг, Дорноговь аймаг, Говь-Алтай аймаг, Төв аймаг, Сэлэнгэ аймаг, Хөвсгөл аймаг, Сүхбаатар аймаг, Хэнтий аймаг, Орхон аймаг, Өвөрхангай аймгууд илүү байна.

**6.2. Салбар, төрөлжсөн архивуудын эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэлт**

2014 онд салбар, төрөлжсөн архивууд нь 1028 заагч, 332 тойм, 362 танилцуулга, 27 данс шинээр үйлдэж, 1589 дансанд дахин боловсруулалт хийжээ.

Салбар, төрөлжсөн архивуудаас эрдэм шинжилгээ-мэдээлэл лавлагааны сан бүрдүүлсэн ажлын тоон үзүүлэлтээрээ Геологийн мэдээллийн төв архив, ЦУОШГ-ын Архив, мэдээллийн хэлтэс, ХХЕГ-ын төв архив, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ний төрөлжсөн архив, Эрүүгийн хэргийн төв архив бусдыгаа тэргүүлж байна.

## **ДОЛОО. ЦАХИМ САН БҮРДҮҮЛЭЛТ**

Засгийн газрын 2013 оны 314 дүгээр тогтоолоор “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн гуравдугаар үе шат /2014-2015 он/ -ны төлөвлөгөө батлагдаж, 2014 оны төсөвт төрийн архивуудын гэрээт ажилтнуудын цалингийн зардал тусгагдсанаар хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтой болжээ. Гэрээт ажилтнуудыг өөр ажилд дайчлахгүйгээр, баримтанд цахим хувь үйлдэх, цахим сан байгуулах ажлыг гүйцэтгүүлж, ажлын норм, төлөвлөгөөний биелэлтэд АЕГ-аас сар бүр хяналт тавьж ажиллаж байгаагийн үр дүнд цахим сан бүрдүүлэлтийн ажил өмнөх оныхоос ерөнхий дүнгээрээс өссөн үзүүлэлттэй байна. Гэрээт ажилтнуудын ажлын дадлага, туршлага ч жил бүр сайжирч байгаа нь үүнд нөлөөлсөн гэж үзэж болно.

**7.1. Цахим сан бүрдүүлэлт /AMS программ дээр/**

Цахим сан бүрдүүлэх чиглэлээр 2014 онд төрийн архивуудаас хийсэн ажлын нэгдсэн үзүүлэлтийг авч үзвэл:

Төрийн архивын ангилал	Тодорхой-лон бичсэн хөмрөгийн тоо	Тодорхой-лон бичсэн дансны тоо	Тодорхой-лон бичсэн ХН-ийн тоо	Тодорхой-лон бичсэн хуудасны тоо	Иж бүрэн цахимд шилжүүлж, ашиглалтад оруулсан хөмрөгийн тоо
Аймаг, нийслэлийн архивууд	1722	2570	52124	1675769	906
Салбар архивууд	186	464	2967502	4165962	481
Төрөлжсөн архивууд	480	76005	560	97545	410
<b>ДҮН</b>	<b>2388</b>	<b>79039</b>	<b>3020186</b>	<b>5939276</b>	<b>1797</b>

Улсын хэмжээнд, нийт төрийн архивууд **2388** хөмрөгийн, **79039** дансны, **3020186** ХН-ийн, **5939276** хуудас баримтыг программд тодорхойлон бичиж оруулсан бөгөөд **2638** хөмрөгийг иж бүрэн цахимд шилжүүлэн, ашиглалтад оруулжээ. Үүнээс аймаг, нийслэлийн архивуудын тодорхойлон бичсэн ХН-ийн тоог харьцуулж үзүүлбэл:

№	Архивын нэр	ХН-ийн тоо	№	Архивын нэр	ХН-ийн тоо
1	Баянхонгор аймаг	19986	12	Завхан аймаг	675
2	Нийслэлийн архивын газар	10417	13	Дундговь аймаг	627
3	Сүхбаатар аймаг	6091	14	Өмнөговь аймаг	506
4	Ховд аймаг	3412	15	Дархан-Уул аймаг	486
5	Өвөрхангай аймаг	1721	16	Дорнод аймаг	468
6	Говь-Алтай аймаг	1464	17	Архангай аймаг	375
7	Увс аймаг	1092	18	Сэлэнгэ аймаг	349
8	Булган аймаг	935	19	Говьсүмбэр аймаг	320
9	Дорноговь аймаг	862	20	Төв аймаг	308
10	Хэнтий аймаг	778	21	Хөвсгөл аймаг	307
11	Баян-Өлгий аймаг	716	22	Орхон	229
<b>ДҮН</b>			<b>52124 ХН</b>		

Эндээс үзвэл Баянхонгор аймгийн Архивын тасаг хамгийн олон буюу 19986 ХН-ийг программд тодорхойлон бичиж оруулсан бол Орхон аймаг түүнээс 87,3 дахин цөөн ХН-д тодорхойлон бичилт хийсэн байна. Хөмрөг үүсгэгч байгууллагуудаас баримтыг нь цахим хэлбэрээр авч байгаатай холбоотой Баянхонгор аймгийн Архивын тасгийн үзүүлэлт харьцангуй өндөр байгаа хэдий ч бусад аймгийн Архивын тасгуудтай харьцуулж үзэхэд Орхон, Хөвсгөл, Төв,

Говьсүмбэр зэрэг аймгийн Архивын тасгуудын тодорхойлон бичилт хийсэн ХН-ийн тоо харьцангуй цөөн буюу 26,5-19,03 дахин бага байна.

### **7.2. Иж бүрэн цахим сан бүрдүүлж, ашиглалтад оруулсан хөмрөгийн тоо:**

Нийт төрийн архивууд 1797 хөмрөгийн баримтыг иж бүрэн цахимд шилжүүлэн, ашиглалтад оруулсан байна. Үүнд:

- Аймаг, нийслэлийн архивууд 906
- Салбар архивууд 481
- Төрөлжсөн архивууд 410 хөмрөгийн баримтаар иж бүрэн цахим сан бүрдүүлж, ашиглалтад оруулсан байна.

### **7.3. Архивын баримтанд цахим хувь үйлдсэн байдал**

Нийт төрийн архивууд 2454 хөмрөгийн, 2729 дансны, 608822 ХН-ийн, 14.073.531 хуудас баримтыг скайнердан цахим хэлбэрт шилжүүлжээ. Үүнд:

Архивын төрөл	Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын тоо хэмжээ			
	Хөмрөг	данс	ХН	хуудас
Аймаг, нийслэлийн архивууд	1906	1299	46716	3412917
Салбар архивууд	323	495	504062	10.425.712
Төрөлжсөн архивууд	225	935	58044	234902
<b>Нийт дүн</b>	<b>2454</b>	<b>2729</b>	<b>608822</b>	<b>14.073.531</b>

Цахим хэлбэрт шилжүүлсэн ХН-ийн тоог төрийн архив тус бүрээр гарган харуулбал:

№	Архивын нэр	Цахим хувь үйлдсэн ХН тоо	№	Архивын нэр	Цахим хувь үйлдсэн ХН тоо
<b>Аймаг, нийслэлийн архивууд</b>					
1	Баянхонгор аймаг	14147	13	Дорноговь аймаг	687
2	Нийслэлийн архивын газар	11091	14	Дундговь аймаг	667
3	Ховд аймаг	3412	15	Хөвсгөл аймаг	657
4	Говьсүмбэр аймаг	3232	16	Увс аймаг	651
5	Дорнод аймаг	1953	17	Булган аймаг	597
6	Говь-Алтай аймаг	1569	18	Орхон	564
7	Өвөрхангай аймаг	1368	19	Хэнтий аймаг	544
8	Сүхбаатар аймаг	1227	20	Архангай аймаг	365
9	Завхан аймаг	977	21	Дархан-Уул аймаг	66
10	Өмнөговь аймаг	965	22	Сэлэнгэ аймаг	450
11	Төв аймаг	800			
12	Баян-Өлгий аймаг	728	<b>АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН</b>		<b>46716</b>

				<b>АРХИВЫН ДҮН:</b>	
Салбар, төрөлжсөн архивууд					
1	Геологийн мэдээллийн төв архив	464	7	ХХЕГ-ын төв архив	706
2	Улсын бүртгэлийн төв архив	422186	8	Гадаад харилцааны төв архив	764
3	ЦУОШГ-ын Архив, мэдээллийн хэлтэс	75981	9	ЦЕГ-ын Төв архивын газар	1657
4	ГХГЗЗГ-ын Мэдээллийн төв	5431 цэгийн мэдээлэл, 637 ш зураг	10	Эрүүгийн хэргийн төв архив	2394
5	Батлан хамгаалахын төв архив	52098	11	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны Төрөлжсөн архив	395
6	Төмөр замын төрөлжсөн архив	30	<b>САЛБАР, ТӨРӨЛЖСӨН АРХИВУУДЫН ДҮН:</b>		<b>556675 ХН 5431 цэгийн мэдээлэл, 637 ш зураг</b>
<b>Нийт төрийн архивуудын дүн</b>			<b>603391 ХН 5431 цэгийн мэдээлэл 637 ш зураг</b>		

Архивын баримтыг цахим хэлбэрт оруулах ажлын хүрээнд аймаг, нийслэлийн архивуудаас архивын баримтын цахим хувь үйлдсэн ХН-ийн тоогоороо Баянхонгор аймгийн Архивын тасаг, Нийслэлийн архивын газар, Ховд, Говьсүмбэр аймгуудын Архивын тасгууд тэргүүлсэн байна. Төмөр замын төрөлжсөн архив хоёрхон хүнтэй ажиллаж байгаа нь цахим архив байгуулах ажлын үр дүнд муугаар нөлөөлсөн байна.

## **НАЙМ. АРХИВЫН БАРИМТЫН АШИГЛАЛТ**

### **8.1. Аймаг, нийслэлийн архивын баримт ашиглуулах үйл ажиллагаа**

2014 онд Аймаг, нийслэлийн архивууд **41763** байгууллага, иргэдэд **56938** лавлагаа олгож, **243052** архивын баримтыг ашигласан байна. Эдгээр 22 архивын хүлээн авсан захиалгаас 7648 нь гараагүй байна. Лавлагааны төрлийг авч үзвэл, тушаалынх 38698, цалингийнх 11158, хүн амын тооллогынх 425, эхийн одонгийнх 255, бусад лавлагаа 7729 байна.

Аймаг, нийслэлийн архивуудаас 2014 онд олгосон лавлагааны тоон үзүүлэлтийг авч үзвэл:

<b>№</b>	<b>Нэр</b>	<b>Лавлагааны тоо</b>	<b>№</b>	<b>Нэр</b>	<b>Лавлагааны тоо</b>
1	Нийслэлийн архивын газар	<b>14465</b>	12	Баян-Өлгий аймаг	1250

2	Төв аймаг	<b>7704</b>	13	Хэнтий аймаг	1049
3	Завхан аймаг	<b>4374</b>	14	Хөвсгөл аймаг	1016
4	Дорнод аймаг	4160	15	Дорноговь аймаг	985
5	Архангай аймаг	3606	16	Сүхбаатар аймаг	976
6	Дархан-Уул аймаг	3503	17	Говь-Алтай аймаг	972
7	Сэлэнгэ аймаг	2977	18	Баянхонгор аймаг	953
8	Өвөрхангай аймаг	2760	19	Өмнөговь аймаг	836
9	Ховд аймаг	1600	20	Дундговь аймаг	762
10	Булган аймаг	1340	21	Говьсүмбэр аймаг	183
11	Орхон	1310	22	Увс аймаг	157
<b>ДҮН</b>			<b>56938</b>		

Эндээс Нийслэлийн архивын газар, Төв, Завхан, Дорнод аймгуудын Архивын тасаг хамгийн их лавлагаа гаргасан бол Говьсүмбэр, Увс аймгийн Архивын тасгууд түүнээс 42,1-49 дахин бага лавлагаа гаргасан нь төрийн архивуудын ажлын ачаалал харилцан адилгүй байгааг харуулж байна.

## **8.2. Салбар, төрөлжсөн архивуудын баримт ашиглуулах үйл ажиллагаа**

Салбар, төрөлжсөн архивууд нь 2014 онд 15152 иргэн, байгууллагуудад 243393 лавлагаагаар үйлчилж, 97761 баримтыг ашиглуулсан байна. Нэгдсэн тоон үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

Үйлчилгээний төрөл	Үйлчлүүлсэн байгууллага иргэний тоо	Олгосон лавлагааны тоо	Ашиглалтад олгосон баримтын тоо /ХН-ээр/
Архивын төрөл			
Салбар архивууд	1162	209865	43030
Төрөлжсөн архивууд	13991	33528	54731
<b>Нийт дүн</b>	<b>15152</b>	<b>243393</b>	<b>97761</b>

Салбар архивуудын үйл ажиллагааны чиглэлээр гардаг баримтууд нь тусгай төрлийн баримтын нэг төрөлд хамаардаг бөгөөд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад илүү лавлагаа олгодог онцлогтой байна.

2014 онд олгосон лавлагааг салбар, төрөлжсөн архив тус бүрээр гарган үзүүлье.

№	Архивын нэр	Лавлагааны тоо
1	Геологийн мэдээллийн төв архив	68099
2	УБЕГ-ын Төв архив	14963
3.	ЦУОШГ-ын Архив, мэдээллийн хэлтэс	126393
4	ГХГЗЗГ-ын Мэдээллийн төв	410
5	Батлан хамгаалахын төв архив	8741
6	Төмөр замын төрөлжсөн архив	4299

7	ХХЕГ-ын төв архив	2200
8	Гадаад харилцааны төв архив	5135
9	ЦЕГ-ын Төв архивын газар	1657
10	Эрүүгийн хэргийн төв архив	3599
11	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны Төрөлжсөн архив	7897
	<b>Дүн</b>	<b>243393</b>

Үүнээс үзэхэд гаргасан лавлагааны тоогоороо ЦУОШГ-ын Архив, мэдээллийн хэлтэс, Геологийн мэдээллийн төв архив, УБЕГ-ын Төв архив тэргүүлж байгаа бол ГХГЗЗГ-ын Мэдээллийн төв хамгийн цөөн лавлагаа гаргасан байна.

**8.3. Дүгнэлт:** Архивын баримтыг байгууллага, иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хангах, шинжлэх ухаан, нийгэм, танин мэдэхүйн зорилгоор ашиглуулах үйл ажиллагаа нь төрийн архивуудад сайн байна. 2014 онд төрийн архивууд үзэсгэлэн зохион байгуулахад зориулж 2118, хэвлэн нийтлэхэд 693, радио, телевизийн нэвтрүүлэг бэлтгэхэд 121 баримтыг ашиглуулсан байна.

Архивын тухай хуулийн 15.1.9, 15.1.10-т заасныг хэрэгжүүлэх, архивын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор архивын үйл ажиллагааг радио телевизээр сурталчлах, үзэсгэлэн зохион байгуулах, эмхэтгэл хэвлүүлэх, ном гаргах зэргээр архивын баримтыг олон хэлбэрээр ашиглуулж байгаа нь сайшаалтай байна.

### **ЕС. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, АРГА ЗҮЙН АЖИЛ**

Архивын тухай хуулийн 15.1.9-дэх заалт, Төрийн архивын үндсэн зааврын 8.3, 8.4, 8.5-дах заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд архивууд үйл ажиллагааны чиг үүрэг, архивын баримтын онцлогийг тусгасан норматив-арга зүйн баримт бичгийг боловсруулан, дагаж мөрдүүлж байна. Үүнд аймаг, нийслэлийн архивууд **71**, салбар архив **21**, төрөлжсөн архив **6** арга зүйн баримтыг тус тус боловсруулан гаргасан байна.

Нийслэлийн архивын газраас эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж, нийт 28 түүхчилсэн лавлах, 4 тоймыг байгууллагынхаа вэб сайтад байршуулж, онлайн хэлбэрээр ашиглуулсан нь сайшаалтай байна.

Гэвч архивын бусад ажилтай нь харьцуулбал архивын эрдэм шинжилгээ, арга зүйн ажил харьцангуй доогуур байна.

### **АРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

#### **10.1. Төрийн архивуудын 2014 оны үндсэн үйл ажиллагааны үр дүн**

Төрийн архивуудын 2014 оны үндсэн үйл ажиллагаа нь “Хангалттай” гэсэн үнэлгээтэй байна.

Төрийн архивууд нь 2014 онд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 21.1-д заасан “Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, цахим мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх”, “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн гуравдугаар үе шат /2014-2015 он/ -ны хэрэгжилтийг эрчимжүүлэх, иргэдэд төрөөс үзүүлэх лавлагаа, мэдээллийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд архивын баримтыг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг үндсэн зорилтоо болгон дэвшүүлж, тодорхой амжилтанд хүрсэн байна.

Нийт төрийн архивын хэмжээнд цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын тоо өмнөх оныхтой харьцуулбал 1,04 хувиар өссөн ба **1797** хөмрөгийн баримтыг иж бүрэн цахимд шилжүүлэн, ашиглалтад оруулж, иргэдэд мэдээллээр хөнгөн шуурхай ашиглуулах боломжтой болсон байна.

Мөн төрийн архивуудын нөхөн бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, тоо бүртгэл, ашиглалтын үйл ажиллагаа нийт дүнгээрээ өссөн үзүүлэлттэй байна. Ялангуяа баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулахад жигд анхаарч, архивын байр, хадгаламжийн сангийн багтаамжийг нэмэгдүүлэх, өрөө тасалгааг засварлах, нягт шүүгээ, тавиур авах, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Аймгийн архивуудад баримт нь хадгалагдаж буй байгууллагуудын жагсаалтыг АЕГ-ын цахим хуудсанд байршуулснаас гадна төрийн архивууд баримтын болон үйл ажиллагааны талаарх мэдээллээ байнга тавин ашиглуулж байна. Тухайлбал, “Гэрэл зураг түүх өгүүлнэ” сэдвийн дор Хэнтий аймаг, Ховд аймаг, Хөвсгөл аймаг, Булган аймгуудын архивын тасагт хадгалагдаж буй 75 гэрэл байршуулж сурталчилсан байна. Баянхонгор, Говь-Алтай аймгийн архивууд үйл ажиллагааныхаа талаарх мэдээллээ АЕГ-ын цахим хуудсаар хамгийн олон удаа сурталчилжээ. Цахим хуудасны үйл ажиллагаагаараа Нийслэлийн архивын газар тэргүүлж байна. Төрийн архивуудын 2014 оны тайлангаас үзэхэд, архивын баримт ашиглуулж буй гол хэлбэр нь байгууллага, иргэдийн хүсэлтээр лавлагаа, хуулбар гаргаж үйлчлэх явдал хэвээр байгаа ба үүнд төрийн архивууд ихээхэн цаг хугацаа зарцуулж байгаа нь хяналт шинжилгээний дүнгээс харагдаж байна.

## **10.2. Хяналт шинжилгээний явцад ажиглагдсан зөрчил, дутагдал**

1. Төрийн архивуудаас ирүүлсэн тайлан, мэдээ нь Төрийн архивын ажлын үндсэн зааврын 9.4.2 болон Үндэсний архивын газрын даргын 2003 оны 153 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн архивын үйл ажиллагааны тайлан, статистик мэдээ гаргах, дүгнэх журам”-ын 2.3-т заасан шаардлагыг хангахгүй байна. Үүнд:

- Бичвэр тайланд байгаа тоо нь статистик мэдээтэйгээ зөрсөн;
- Тайлан мэдээг бодитой гаргаагүй, дүн тоог өсгөж, эсвэл, зөрүүлж бичсэн;



- Баримтын тоо хэмжээг Төрийн архивын ажлын үндсэн зааврын 4.2.3-т заасан тоо бүртгэлийн нэгж хэмжигдэхүүнээр гаргаж хэвшээгүй;
- Архивууд сан хөмрөгтөө хүлээн авсан удирдлагын баримтаас бусад тусгай төрлийн баримтууд /гэрэл зургийн баримт, зураг төслийн баримт, хувийн гаралтай баримт г.м/-ын иж бүрдлийг бие даасан ХН болгон бүртгэдэггүй;
- Хувийн хөмрөгт хүлээн авсан өөр өөр төрлийн баримтуудыг нэг ХН болгон бүртгэдэг;
- Тоо бүртгэлийн баримт бичгийг үнэн зөв хөтөлж, тухай бүр тэмдэглэл хийж хэвшээгүй;
- Архивын дарга нар өөрсдөө мэдээ тайлангаа гаргаж нэгтгэдэггүй зэрэг зөрчил түгээмэл байна.

Ийнхүү тайлан мэдээг буруу гаргасан, дүн тоо нь хэт их зөрүүтэй бичигдсэн нь хяналт-шинжилгээний ажилд хүндрэл учруулж, бодит дүгнэлт гаргах боломжгүй болгож байна.

2. Иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажил арга зүйн хувьд дутагдалтай, ББНШАЗК-ын үйл ажиллагаа жигд биш байна.
3. Зураг төслийн баримтаар архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх ажил ихэссэн ч тэдгээр баримтыг ангилан төрөлжүүлэх, эмхлэн цэгцлэх, тоо бүртгэлд оруулах ажил хангалтгүй байна.

### **10.3. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмж**

Цаашид нийт төрийн архивууд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган, биелэлтийг улирлаар гаргаж ирүүлж байхыг зөвлөмж болгож байна.

1. Төрийн архивын ажлын үндсэн зааврын 9.4.1-д заасны дагуу архивын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Үндэсний хөтөлбөр, бусад бодлогын баримт бичгүүд, АЕГ-аас дэвшүүлсэн зорилт, архивын өмнө тулгамдсан асуудалтай нягт уялдуулах;
2. Архивын үйл ажиллагааны тайлан, мэдээг Төрийн архивын ажлын үндсэн зааврын 9.4.1, Үндэсний архивын газрын даргын 2003 оны 153 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн архивын үйл ажиллагааны тайлан, статистик мэдээ гаргах, дүгнэх журам”-ын 2.3-т заасан шаардлага, АЕГ-аас хүргүүлсэн загвар, чиглэлийн дагуу үнэн зөв, бодитой гаргаж, жил бүрийн 12 сарын 05-ны дотор ирүүлж байх;
3. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд холбогдох бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг дараах чиглэлээр гаргаж, хугацаанд нь АЕГ-т ирүүлж байх. Үүнд:
  - Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-

- шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтын дагуу гаргаж жил бүрийн 6 сарын 01, 12 сарын 01-ний байдлаар гаргаж ирүүлэх
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт архив, албан хэрэг хөтлөлтийн талаар тусгагдсан асуудлуудын хэрэгжилтийн тайлан, мэдээг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын 7 дугаар хавсралтын дагуу гаргаж, жил бүрийн 06 сарын 05, 12 сарын 10-ны дотор тус тус ирүүлэх;
  - 4. Хөмрөгийн баримтанд иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажил хийж, данс бүртгэлийг шинэчлэхдээ хөмрөгийг зөв сонгох, хуучин дансыг хөмрөгийн хэрэгт хадгалах, дансанд шилжүүлэх хүснэгтийг заавал үйлдэх;
  - 5. Цахим баримтыг бүртгэх, цахимд шилжсэн хөмрөг, данс, ХН-ийн бүртгэл болон тоо бүртгэлийн баримт бичгүүдэд зохих тэмдэглэлийг үнэн зөв, гүйцэд хийж хэвших;
  - 6. Программ хангамж, цахим мэдээллийн сан, цахим баримтын аюулгүй байдлыг хангах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах /мэдээллийн санг нөөцлөх, бодлого, дэг, журам тогтоож мөрдүүлэх гм/
  - 7. Архивын зориулалтын байртай болох, хадгаламжийн сангийн багтаамжийг нэмэгдүүлэх, нягтруулсан шүүгээ авах, техник хэрэгслийг шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд анхаарч, хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах
  - 8. Архивын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, архивын баримтын талаарх мэдээллээр иргэд байгууллагыг шуурхай хангах зорилгоор төрийн архивууд бие даасан цахим хуудастай болох, салбар, орон нутгийн удирдах байгууллагын цахим хуудсанд архивын болон баримтын талаарх мэдээллийг байрлуулж, тухай бүр шинэчилж байх зэрэг болно.

Мөн АЕГ-аас тусгай төрлийн баримтыг эмхлэн цэгцлэх, сан хөмрөгөө нөхөн бүрдүүлэх, данс бүртгэл үйлдэх, тоон мэдээ, тайлан гаргах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх, заавар, журам, гарын авлага боловсруулж, мөрдүүлэх шаардлагатай болсныг хяналт-шинжилгээний дүн харуулж байна.

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС